



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/ЗЧН

Мандалговь

“Зүүн болон говийн бүс-2022” бүсийн аварга шалгаруулах үсчин, гоо засалчдын тэмцээнд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан” Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4, 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 9 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Зүүн болон говийн бүс-2022” бүсийн аварга шалгаруулах үсчин, гоо засалчдын тэмцээнд дэмжлэг үзүүлсүгэй.
2. Дээрх арга хэмжээний дэмжлэгт шаардагдах 2,050,000 (Хоёр сая тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

. 4822100611

Аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар
сарын 31-ний өдрийн 15 дугаар
захирамжийн хавсралт



ҮСЧИН ГОО ЗАСАЛЧДЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

№	Зардлын нэр	х/н	тоо хэмжээ	нэгжийн үнэ	бүгд үнэ
1	Зочид буудлын зардал	өдөр	7*3	50,000	1,050,000
2	Шүүгчийн зардал	өдөр	3	200,000	600,000
3	Тэмцээний байр	өдөр	2	200,000	400,000
ЭЦСИЙН ДҮН:					2,050,000